



**МОНГОЛ УЛС**  
**ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

213300 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272287

2014.02.21 № 03/31-17

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

ТӨВ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА Ж.ОТГОНЧУЛУУН  
ТАНАА

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төв аймгийн Статистикийн хэлтсийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон Санхүүгийн байдлын тайлан, Санхүүгийн үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулгад аудит хийв.

**Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх үүрэг хариуцлага:**

Төв аймгийн Статистикийн хэлтсийн удирдлага санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 26-р зүйлд заасны дагуу Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг.

Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

**Аудиторын хүлээх хариуцлага:**

Хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах нь бидний үүрэг юм. Бид аудитаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан Улсын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, аргачлал, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл:**

Төв аймгийн Статистикийн хэлтсийн хэлтсийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, түүвэрчлэн шалгах аудитын горимыг хэрэгжүүлж, аудитын явцад нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, тооцоолуудыг нарийвчилсан сорилын аргаар шалгадаг.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэн хэрэгжүүлснээр 2013 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан нь УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаал, 2013 оны 269 тоот тушаалуудаар Улсын төсвийн нягтлан бодох

бүртгэлийн бодлого, заавар, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт:**

Төв аймгийн Статистикийн хэлтсийн хэлтсийн 2013 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үлдэгдэл баланс, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлэгдсэн байна

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЖАРГАЛСАЙХАН